

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН ЗАХИРАГЧИЙН 2009-2012 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТИЙН ЯВЦЫН ТУХАЙ ТАНИЛЦУУЛГА

/2010 оны 4-р сарын 1-ний байдлаар/

НИТХ-ын 2008 оны 12-р сарын 22-ны өдрийн 2/06 дугаар тогтоолоор батлагдсан Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2009-2012 оны үйл ажиллагааны хөтөлбөрт:

- | | |
|---|----------|
| 1. “Эдийн засгийн хөгжил” нэгдүгээр бүлэгт | 20 заалт |
| 2. “Иргэдийн амьжиргааны чанарыг сайжруулах зорилт” хоёрдугаар бүлэгт | 73 заалт |
| 3. “Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжил” гуравдугаар бүлэгт | 68 заалт |
| 4. “Экологи-Байгаль орчны талаархи үйл ажиллагаа” дөрөвдүгээр бүлэгт | 23 заалт |
| 5. “Нутгийн захиргааны ажлыг төгөлдөршүүлэх талаар” тавдугаар бүлэгт | 18 заалт |
- нийт 202 заалт төлөвлөгдсөн.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийг бүлгээр харуулбал:

/2010 оны 4-р сарын 1-ний байдлаар /

№	Агуулга	Нийт зорилтын тоо	Нийт заалтын тоо	Хэрэгжилтийн явц							Хувь		
				Хугацаа болоогүй	Биелсэн	Хэрэгжиж эхлээгүй	Хэрэгжих шатандаа	Үүний дотор					
								90%	70%	50%		30%	10%
1	Эдийн засгийн хөгжлийн талаар	2	20			2	18			5	11	2	30
2	Иргэдийн амьжиргааны чанарыг сайжруулах зорилт	7	73	2	1	11	59			38	20	1	36.8
3	Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн талаар	6	68			8	59	1		10	45	4	29.1
4	Экологи, байгаль орчны талаархи үйл ажиллагаа	1	23			1	22			9	12	1	35.7
5	Нутгийн захиргааны ажлыг төгөлдөршүүлэх талаар	1	18				18			13	5		44.4
Нийт		17	202	2	1	22	176	1		75	93	8	35.2

2010 оны 4-р сарын байдлаар Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт 35,2 хувь байна. Үйл ажиллагааны хөтөлбөрийн:

- 0.9 хувь буюу 2 заалтын хэрэгжих хугацаагүй болоогүй байна.
- 0.6 хувь буюу 1 заалт 100 хувийн
- 87.6 хувь буюу 177 зорилт нь 10-50 хувийн,
- 10.9 хувь буюу 22 зорилт хэрэгжиж эхлээгүй байна.

Нийслэлийн Эдийн засаг, нийгмийн 2010 оны зорилтын хэрэгжилтийг бүлгээр харуулбал:

/2010 оны 4-р сарын 1-ний байдлаар/

№	Агуулга	Нийт зорилтын тоо	Нийт заалтын тоо	Хэрэгжилтийн явц							Ххасуулах саналтай	Хувь		
				Хугацаа болоогүй	Биелсэн	Хэрэгжиж эхлээгүй	Хэрэгжих шатандаа	Үүний дотор						
								90%	70%	50%			30%	10%
1	Эдийн засгийн хөгжлийн талаар	20	53	3	1	7	42		2	2	18	20		21.6
2	Нийгмийн амьжиргааны чанарыг сайжруулах талаар	72	176	32	12	7	125		2	9	83	31		31.88
3	Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжлийн талаар	67	142	12	1	12	116			5	57	54	1	20.16
4	Экологи, байгаль орчны талаар	23	58	7		2	48				21	27	1	18
5	Эрх зүй, нутгийн захиргааны ажлыг боловсронгуй болгох талаар	18	87	16	5	3	63		1	7	37	18		31.13
Нийт		200	516	70	19	31	394		5	23	216	150	2	24.55

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр хэрэгжиж эхэлснээс хойш 1.5 жил болж байгаа хэдий боловч үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зарим зорилтуудыг эрчимжүүлэх шаардлагатай байгааг бүлэг бүлгээр нь авч үзвэл:

“Эдийн засгийн хөгжил” нэгдүгээр бүлэгт :

1. 1.1.3. Улаанбаатарын бүсэд дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай, шинэ технологид суурилсан үйлчилгээ, оюуны багтаамжтай, бага оврын бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг түлхүү хөгжүүлнэ
2. 1.2.1. Хотын хүнсний нөөц бий болгоно
3. 1.2.2. Нийслэлийн хүн амын хэрэгцээнд зориулан 20-30 мянган тн махны байнгын эргэлтийн нөөцтэй байх “Махны нөөцийн сан” байгуулна
4. 1.2.5. Газар тариалангийн аймгуудтай Гэрээтэй ажиллах замаар хотын гурилын болон хүнсний ногооны хангамжийг дотоод эх үүсвэрээр гурван жилийн дотор бүрэн шийдвэрлэнэ.
5. 1.2.6. Хотын дүүргүүдэд сүүний хөргөлтийн 5 төв, ариутгасан сүү борлуулах 10 загвар цэг, хүүхдийн сүүн тэжээлийн 2 үйлдвэр байгуулна.
6. 1.2.7. “Хүүхэд бүрт нэг аяга хүү” аян өрнүүлнэ.
7. 1.2.8. Мал эмнэлгийн лабораторийг Эмээлтэд байгуулна
8. 1.2.9. Хүнсний аюулгүй байдлын хяналт шинжилгээ хийх үндэсний лабораторийг ХХААХҮЯ-тай хамтран байгуулна.

“Иргэдийн амьжиргааны чанарыг сайжруулах зорилт” хоёрдугаар бүлэгт:

1. 2.1.2. Улаанбаатар хотын хүн амын дотоод шилжилт хөдөлгөөн, гадна орчноос шилжин ирэгсэдийн урсгалыг бүртгэх онлайн мэдээллийн системийг 2009 онд нэвтрүүлнэ
2. 2.1.3. Хотын гэр хорооллын хүн амыг сийрэгжүүлэхийн тулд захын дүүргүүдийн хөгжлийг илүү тэтгэж, тэдгээрт ажлын байр олноор бий болгох, иргэдийн тав тухтай амьдрах орчныг бүрдүүлэхэд чиглэгдсэн төлөвлөлт, зохион байгуулалтын шинэ ажлуудыг авч хэрэгжүүлнэ. Улаанбаатар хотод шинэ суурьшил бий болгох ажлыг төлөвлөн холбогдох эрх зүйн орчин бүрдүүлж, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжүүлж эхэлнэ
3. 2.2.3. Шинээр бий болгосон ажлын байрны тооноос хамааруулан урамшуулал олгоно
4. 2.2.4. Ажилгүйдлийг бууруулах, орлогыг нэмэгдүүлэх асуудлыг нийслэлийн хүнсний хангамжийг шийдвэрлэх, үйлдвэрлэл, технологийн парк, түлш-эрчим хүчний цогцолбор байгуулах бодлоготой уялдуулан зохицуулна.
5. 2.2.5. Нийслэлд өрхийн нэг сарын дундаж орлогыг 1 саяаас дээш төгрөгт хүргэнэ. Дундаж орлоготой иргэдийн хувь хэмжээг нэмэгдүүлнэ
6. 2.2.6 Цалин, тэтгэвэр, тэтгэмжийг 2008 оны түвшнээс 3 дахин өсгөнө
7. 2.2.12. Зах зээлийн эрэлтэд нийцсэн мэргэжилтэй ажилтан бэлтгэх сургалт, үйлдвэрлэлийн 2-оос доошгүй төв байгуулж, суралцагчдын тоог 50 хувиар нэмэгдүүлнэ
8. 2.2.13. Гадаадын хамтын ажиллагаат хотуудын их дээд сургуульд 50 хүртэл оюутныг тэтгэлэгт хөтөлбөрийн хүрээнд сургана
9. 2.3.8. Эрсдэлт бүлгийн иргэдэд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээ авах нөхцлийг бүрдүүлэх ажлыг төлөвлөж зохион байгуулна.
10. 2.3.11. Халдварт өвчинтэй тэмцэх харуулдан тандалтын тогтолцоог бий болгоно.
11. 2.4.8. ЕБС бүрийг спортын заалтай болгоно
12. 2.4.10. Хөгжлийн бэрхшээлтэй сурагчдыг нийгэмжүүлж ердийн сургалттай сургуульд суралцах боломжоор хангахад чиглэсэн түшиц сургууль байгуулах
13. 2.4.13. Багшийн зуны сургалтын төвийг байгуулна

14. 2.4.14. Амьжиргааны доод түвшингээс доогуур орлоготой 3 ба түүнээс дээш хүүхэд нь ЕБС-д суралцдаг ерхийн нэг хүүхэд улсын их дээд сургуульд элсэн ороход нь “Хотын даргын нэрэмжит тэтгэмж”-ийг нэг удаа олгоно
15. 2.4.15. Оюуны өндөр чадавхитай 5000 сурагчдыг жил бүр дүрэмт хувцас, хичээлийн хэрэгсэлээр урамшуулна
16. 2.5.5. “Хүүхэд, гэр бүлийн хөгжлийн ордон”, “Шинээр төрсөн иргэдийг бүртгэх ёслолын ордон” байгуулна
17. 2.7.5. Шинээр баригдах орон сууцны хорооллуудад соёл, спорт, чөлөөт цагийн цогцолбор байгуулна
18. 2.7.7. Чингэлтэй, Сонгинохайрхан, Баянгол дүүргүүдэд соёлын төв байгуулна
19. 2.7.11. Алслагдсан дүүрэг, захын хороодын иргэдэд орчин үеийн программ хангамж бүхий номын сангийн үйлчилгээг ойртуулж, номын сангуудыг байгуулна

“Хот байгуулалт, дэд бүтцийн хөгжил” гуравдугаар бүлэгт:

1. 3.1.2. “Нийслэлийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-г тодотгоно
2. 3.1.4. Улаанбаатар хотыг 2020 он хүртэл хөгжүүлэх газар зохион байгуулалтын болон хот байгуулалтын төлөвлөгөөтэй уялдуулан хот орчмын бүс, хотын захын нутаг дэвсгэрийг хөгжүүлэхэд шаардагдах дэд бүтцийн хангамжийн хөрөнгө оруулалтын асуудлыг шийдвэрлэх замаар хотын төвийн газар ашиглалт, үйлчилгээний нягтралыг сааруулна. Үүнд:
 - Хотын өсөлтийн менежментийг тодорхой болгох, хотыг дотогш нь нягтруулах, тэлэлтийг баруун тийш нь чиглүүлэх, гэр хорооллыг хязгаарлах бодлого баримталж, хот байгуулалт-газар зохион байгуулалт, төлөвлөлт-хэрэгжилтийн тогтолцоог төгөлдөршүүлнэ.
 - Хот орчмын газрыг аж үйлдвэрийн, хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн, хүнсний нөөцийн зэрэг тодорхой чиг үүрэг бүхий бүсүүд болгон хөгжүүлнэ.
 - Онцгой объектууд /нефть бүтээгдэхүүн, шатдаг хий боловсруулах үйлдвэр, агуулах/-ыг хотоос гаргах асуудлыг боловсруулан шийдвэрлэж аюулгүй орчныг бүрдүүлнэ.
 - Улсын чанартай томоохон объектууд, улс, нийслэлийн чанартай авто замын дагуух газрын хөгжилд түлхүү анхаарч хамгаалалтанд авах санал боловсруулан шийдвэрлүүлж, стратегийн ач холбогдол бүхий томоохон хотхон, суурин байгуулах төсөл боловсруулан гадаадын хөрөнгө оруулалтыг татах нөхцлийг бүрдүүлнэ.
 - Бүх төрлийн ачаа ачих, буулгах, хадгалах ажиллагааг хотын төвөөс гадагшлуулж, “Ачаа тээврийн төрөлжсөн терминаль”-ийг хотын зүүн хэсэгт байршуулна.
 - Хүнд даацын машин механизмын зогсоолыг хотоос гадагшлуулж, ачаа тээврийн замын маршрутыг тогтоож мөрдүүлнэ.
3. 3.1.12. Хотын гэрэлтүүлгийг нэгдсэн удирдлагад шилжүүлэх, Нийтийн эзэмшлийн гудамжны гэрэлтүүлэг, шугам сүлжээг эрчим хүчний хэмнэлттэй технологиор бүрэн шинэчлэх, гэрэлтүүлэг чимэглэлийн үйлдвэр байгуулах,
4. 3.1.13. Орон сууцны хорооллыг иж бүрэн барьж байгуулах зарчим баримталж, нийгмийн үйлчилгээг нормативт хэмжээнд хүргэн, авто болон явган хүний замын хөдөлгөөнийг оновчтой зохицуулж, авто болон явган хүний замын хөдөлгөөнийг оновчтой зохицуулж, “газар доорхи хот” байгуулах шинэ бодлого хэрэгжүүлнэ
5. 3.1.14. Хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хотын гэрэлтүүлэг, чимэглэлийн зориулалтын тоног төхөөрөмжийн үйлдвэрийг байгуулахад дэмжлэг үзүүлнэ
6. 3.1.15. Нийтийн эзэмшлийн зам талбайг нөхөн сэргээх зардлыг урьдчилан төвлөрүүлж, тэдгээрийг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлнэ
7. 3.1.18. Газрын үнэлгээний бүсчлэлийн хил хязгаарыг шинэчлэн, Багахангай, Багануур, Налайх дүүргүүдийг холбосон улсын чанартай авто замын дагуух

- газрыг Нийслэлийн эдэлбэр газарт шилжүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлнэ.
8. 3.1.23. Хотын гол гудамж, талбайн тохижилтонд архитектурын сонгомол шийдлийг тусган хэрэгжүүлнэ
 9. 3.1.24. Хотын гол гудамж, архитектурын сонгомол шийдлийг тусган, дүүрэг бүрт 2 гудамжийг тохижуулна.
 10. 3.2.2. Хотыг дамжин өнгөрөх олон улсын хурдны зам, “Их тойруу” болон хэвтээ чиглэлийн хурдны замуудыг барьж эхэлнэ.
 11. 3.2.5. Транзит автозамын зураг төсөл боловсруулж, өөрийн хөрөнгөөр гүйцэтгэж, дараа төлөгдөх нөхцлөөр түүнийг барьж байгуулахад гадаадын байгууллагуудтай хамтран ажиллана.
 12. 3.2.7. Орон сууцны хорооллын орчимд болон үйлчилгээний төвүүдэд ил ба газар доор 27 мянган автомашины зогсоол бий болгоно.
 13. 3.2.9. Нийтийн тээврийн салбарт “Парк шинэчлэлт” хөтөлбөр хэрэгжүүлнэ. Үүний тулд эхний ээлжинд 80 электробус, хийн түлшээр ажилладаг 2000 таксийг нийтийн тээврийн үйлчилгээнд оруулна
 14. 3.2.10. Нийтийн үйлчилгээний тээврийн хэрэгслийн болон таксийн зогсоол, хийн түлш түгээх станц, нийтийн тээврийн авто аж ахуйн барилга байгууламж, авто вокзал бүхий үйлчилгээний цогцолбор байгуулна
 15. 3.3.8. Боловсруулсан түлш болон байгальд ээлтэй технологиор эрчим хүч үйлдвэрлэж борлуулсан бизнесийн нэгжүүдийг урамшуулах механизм бүрдүүлнэ
 16. 3.4.1. Улаанбаатар хотын ундны усны нөөцөд тулгуурласан менежментийг төлөвшүүлж, Туул, Сэлбэ гол болон түүний цутгал голуудын урсацыг тогтвортой байлгах арга хэмжээг авч, усны хэмнэлттэй хэрэглээг дээдэлсэн ус хангамжийн найдвартай, тасралтгүй, чанартай үйлчилгээг иргэдэд үзүүлнэ.
 17. 3.4.2. “Улаанбаатар хотын цэвэр, бохир усны мастер төлөвлөгөө”-нд тодотгол хийнэ
 18. 3.4.3. Хүн амын ус хангамжийн найдвартай ажиллагааг хангахад ус хангамжийн шинэ эх үүсвэр бий болгоно. Үүнд:
 - Туул, Тэрэлжийн голын ус хуримтлуулах даланг барьж байгуулах ажлыг эхлүүлнэ
 - Ахуйн хэрэглээнээс гарах бохир усыг цэвэршүүлэн ашиглах технологийг нэвтрүүлнэ
 19. 3.4.6. Цэвэр усны шугамыг доторлох шинэ технологи нэвтрүүлнэ. НААСТ-ийн хүрээнд траншейгүй аргаар цэвэр, бохир усны шугамыг суурилуулах тоног төхөөрөмжийг нийлүүлж, 1.2 км цэвэр усны дамжуулах шугамын доторлогоо хийнэ
 20. 3.4.11. “БУЯН 3” төсөл хэрэгжүүлж, Буянт-Ухаа, Яармаг, Нисэхийн орон сууцны хороололд цэвэр усны шинэ эх үүсвэрийн нарийвчилсан судалгаа хийж, цэвэр, бохир усны системийг цэвэрлэх байгууламжийн хамт барина
 21. 3.4.12. Гэр хорооллыг хөгжүүлэх, барилгажуулах ажлын хүрээнд Хайлааст, Зурагт, Чингэлтэй, Дэнжийн 1000, Орбит зэрэг бохир усны гол цуглуулагч шугам барих ажлыг эхлүүлж, 21, Туул-1, 31 III коллекторуудыг барьж ашиглалтанд оруулна
 22. 3.4.13. Арьс шир, ноос боловсруулах анхан шатны үйлдвэрүүдийн цэвэрлэх байгууламжийг шинэ суурьшлын бүсэд барьж эхлэнэ
 23. 3.5.1. Ахуйн үйлчилгээг хот төлөвлөлтийн нормд нийцүүлэн хөгжүүлж, гэр хороолол болон шинээр баригдах хороололд ахуйн үйлчилгээний цогцолбор байгуулна
 24. 3.6.2. Дүүргүүдийн ЗДТГ-т байгууллага, иргэдэд үнэгүй үйлчлэх интернэт, компьютерийн танхим байгуулна

“Экологи-Байгаль орчны талаархи үйл ажиллагаа” дөрөвдүгээр бүлэгт:

1. 4.2. Суурьшлын бүсэд байгалийн түгээмэл тархацтай ашигт малтмал олборлон ашиглаж буй 27 аж ахуйн нэгж, байгууллагын нөхөн сэргээлт

- хийгээгүй орд газруудын талаар цаашид баримтлах бодлогыг тодорхойлон шийдвэрлүүлнэ
2. 4.5. Техникийн боломжийг бүрдүүлэх замаар шөнийн цагаар цахилгаан халаагуур хэрэглэж байгаа гэр хорооллын айл өрхүүдийн цахилгааны үнийг тэглэх боломж бүрдүүлнэ
 3. 4.8. Туул голын ай савд ашигт малтмал олборлох, усны эх үүсвэрүүдийн тэжээлийн мужийн дэглэм зөрчин хамгаалалтын бүсэд зөвшөөрөлтэй, зөвшөөрөлгүй суурьшсан аж ахуйн нэгж, иргэдийн үйл ажиллагааг зогсоох, нүүлгэх, газар чөлөөлүүлэх ажлыг үе шаттайгаар зохион байгуулж, тухайн газруудад нөхөн сэргээлтийг хийлгэх арга хэмжээ авна
 4. 4.13. “Туул, Сэлбэ голын хөгжлийн төсөл”-ийн 1-р үе шатыг хэрэгжүүлж, голын урсацыг тогтмолжуулж, эрэг орчмыг амралт, спорт, чөлөөт цагийн бүс болгон тохижуулах ажлыг эхлүүлнэ. Дунд голыг тохижуулах зураг төсөл боловсруулж хэрэгжүүлнэ
 5. 4.15. Хотод нийтийн бие засах газрын тоог нэмэгдүүлнэ.
 6. 4.21. Даавуун болон цаасан тор, уутны үйлдвэрлэлийг дэмжиж, хүнсний бүтээгдэхүүнд эрүүл ахуйн стандартын шаардлага хангасан сав баглаа боодол хэрэглүүлдэг болгоно

“Нутгийн захиргааны ажлыг төгөлдөршүүлэх талаар” тавдугаар бүлэгт:

1. 5.11. Шилжин ирэгсэд зөвхөн төлөвлөгдсөн бүсэд суурьшин төрийн болон нийгмийн үйлчилгээ авах боломжийг бүрдүүлж, журамтай шилжилтийн тогтолцоог нэвтрүүлнэ

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан дээрхи 58 зорилтыг хэрэгжүүлэхэд НЗДТГ, ЗАА, дүүргүүд, нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд, ЗАА-ны харьяа байгууллагууд онцгой анхааран ажиллахаас гадна хөрөнгө шаардагдахгүй, зөвхөн тухайн байгууллагын зохион байгуулалтаас шалтгаалан хэрэгжилт нь удааширч байгаа заалтуудын хэрэгжилтийг эрчимжүүлэхэд санаачилгатай ажиллах нь зүйтэй байна.

Нийслэлийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт тусгагдсан зорилтуудын хэрэгжилтэнд байгууллага бүр дүн шинжилгээ хийж, “Монгол Улсын 2011 оны төсвийн тухай хуулийн төсөл”, “Нийслэлийн эдийн засаг, нийгмийн 2011 оны зорилтын төсөл”, “Нийслэлийн 2011 оны төсвийн төсөл”, “Нийслэлийн 2010 оны төсвийн тодотгол”-д тусгуулах талаар одооноос холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах шаардлагатай байна.

Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагуудаас үл хамаарах шалтгаанаар хэрэгжих боломжгүй зорилтын талаархи саналаа НЗДТГ-т яаралтай ирүүлнэ үү.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР